

**141 ХРИСТ ДОТОР, ХРИСТТЭЙ ХАМТ,ХРИСТИЙН ТӨЛӨӨ**

Ерөөгдсөн замаар алхаж, "хэвийн" амьдралаар амьдрах гэдэг нь: Эзэнийг өмнөө тавьж, Түүнийг зүрх сэтгэлдээ үргэлж урьж, бүх зүйлд Түүнд талархаж, Үгийг өдөр шөнөгүй бясалгадаг байх юм.

Үгэнд итгэж, хайр дотор итгэлээ хөгжүүлэх замаар Христ доторх ялалтын нотолгоог бий болгоно. Түүний хүслийг зааврын дагуу үйлдэх; Үг айлдахад тэнгэр захирдаг. Тэнгэр нь таны дотор байна. Таны үйлдлийг Бурхан жинлэнэ. Дуулгавартай байснаар зүрх сэтгэлд тань амар амгалангийн шинж төрх байх болно.

"Бурханыг харахад энэ нь сайн байлаа." "Хэвийн" гэдэг нь "Түүний нүдэнд сайн" ба тэнцвэртэй амьдралаар амьдрах юм. Энэ тэнцвэр нь таны дотор урсах Бурханы хүчийг баталдаг.

Түүний оршихуйд амьдрах гэдэг нь өмнөө Эзэнийг тавих гэсэн үг юм. Та Түүний цаг хугацаа, зам ба хайрын хүч чадлыг мэдэж, мөн "Хэвийн" нь таныг бусдад нигүүлсэл дотор ерөөлийн суваг болгоно.

.<sup>36</sup>Учир нь Түүнээс, Түүгээр, Түүнд бүх юм байна. Түүнд алдар нь үүрд байх болтугай. Амен. (Ром 11:36 АБ 2004)

**141.1 ЭЗЭН ЭМЭЭХ**

Эзэнээс эмээгтүн. Эзэнээс эмээнэ гэдэг нь бузар муугаас холдон жигших гэсэн утгатай. Энэ нь мэдлэг ба мэргэн ухааны ундарга, амьдралын чанар,эд баялаг, эрүүл мэнд, нэр төрийг харах нүдийг нээж өгдөг. “Эзэнээс эмээхүй” нь ерөөлийн зам руу таныг хөтөлж элбэг, сэтгэл хангалуун амьдралыг өгдөг. Энэ нь дэлхийгээс өгөх шагналын мөнхийн номынхоо хуудсыг бичихэд чиглүүлдэг.

Энэ нь таныг мэргэн ухааны жинхэнэ мэдлэг, зааварчилгааг эзэмших ба хүндэтгэл, эд баялаг хүртэх замыг олж авахад чиглүүлдэг.

Энэ нь таныг бузар муугаас болон бүх хараалын үүднээс холдуулж ,  
Бурханы эрдэнэсийн хайрцгийг нээж, бузар муугаас хамгаалж,  
тэнгэр элч нараар хамгаалан хүрээлүүлдэг. Эзэнээс эмээх нь бузар  
мууг үзэн ядах явдал юм. Дахин ухаалаг байж,  
цагаа хэмнэ; цагаа хэмнэ! Сүнстэй хамт Үгэн дотор, төлөвлөж  
бясалга. Таныг үр жимсээр шагнадаг Их Эзэнд таалагдах нэр  
төртэй амьдралыг бий болго. Түүний нэрийг алдаршуул!

## **141.2 ХОНЬЧНЫХОО ДУУГ ТА СОНСОЖ БАЙНА УУ?**

Та Үгэнд дуртай юу?

Та үүнийг өдөр шөнөгүй бясалгадаг уу?

Та Түүнийг сонсож байна уу?

Та Үгийг сонсох чихтэй юу?

Талархлын зүрх үүнийг гэрчлэх болно. Есүс Христ бол аврал,  
мөнхийн амьдрал мөн Ариун Сүнсийг өгсөн хоньчин юм.

Цэвэр зүрх нь Бурханыг харж, хонь нь Түүний дууг сонсох болно  
гэж бичсэн байдаг. Тиймээс бясалгал болон залбирлын үеэр Үгийг  
сонсоорой.

Түүнийг сонсох хүртлээ өөрийн дотоод дуу хоолойгоо дараарай.  
Анхдагч ойлголтын багшийн байр сууриндаа байж болохгүй. Үгийг  
өөрийн тайлбараар бүү сулруул. Энэ нь хүмүүсийн чихэнд чимэгтэй  
байж хүлээн зөвшөөрөгдөх боловч махан биеийн шунал тачаалыг  
даван туулах хүч чадалгүй байна. Хоньчин хониныхоо төлөө амиа  
өгсөн. Бурхан өөрчлөгддөггүй; Тэр бол өчигдөр ч, өнөөдөр ч  
хэвээрээ. Үг хэзээ ч өөрчлөгдөхгүй. Тэгэхээр та оюун ухаанаа хаана  
төвлөрүүлдэг вэ?

"Хэвийн" хүүхэд залбирал, мөргөлөөр Бурхантай уулзаж байгаль  
дэлхий, мэдээ гэх мэтээс өдөр бүр Түүний үгийг олж харна.

Бурханы хүүхэд чин сэтгэлтэй (дэлгэрэнгүй наманчлах) байвал

амьд Бурхантай уулзах болно. Та хэр олон уулздаг вэ ?Зөвхөн хэцүү үед үү? Та хайртай хүнтэйгээ хэр их уулздаг вэ?

### **141.3 СУВГИЙГ ЦЭВЭРЛЭХ**

Бурхан цэвэр савыг хэрэглэдэг. Тиймээс саваа цэвэрлэж, бэлтгэснээр Бурхан цаг нь болохоор хэрэглэнэ. Түүний цагаас бүү зөрөөрэй. Түүний ажлыг хийж байгаа ч Бурханд үл таалагдах зүйлсээ арилгахгүй л бол та Бурханы хүчийг харахгүй. Шунал бол шүтээн шүтэх явдал бөгөөд ялзрал сүйрэл, дэмий хоосон амьдралд хүргэдэг. Сатан хөнөөж, хулгай хийхээр ирсэн, шунал бол хаалга нь юм.

### **141.4 ИТГЭЛИЙН ЕРӨӨЛИЙН ЗАМ**

Дүн тавихын оронд итгэлийн зам юугаар (хэн, хаана ) яаж ирж байгааг няхуур ажигла. Бурханы нээсэн итгэлийн замыг хар. Бурхан итгэлийн үйлсийг хүсдэг. Та ерөөлийг мөнгөөр худалдаж авах боломжгүй. Итгэл гэх хаалгаар л ерөөл дамжин орж ирдэг учраас итгэлийн баатар болоорой. Итгэл бол Бурханаас өгсөн асар том бэлэг юм. Үг тэмдэг ба гайхамшгуудыг авчирдаг.

### **141.5 БУРХАНЫ ХҮЧИЙН ДАГУУ**

Эш үзүүллэгийн бэлгүүдийг өгдөг Бурханыг хүлээн зөвшөөрснөөр та Түүний ажлыг гүйцэлдүүлэх болно. Түүний хаанчлал ба зөвт байдлыг эхлээд хайвал бүх хэрэгцээ хангагдана гэж Тэр амласан. Хүчтэй хүсэл эрмэлзэлтэй ч Үгийн баяр баясгалангүй, эсвэл дуулгавартай байхдаа хойрго байдаг хүнд Ариун Сүнсний ул мөр байх болов уу? Бурхан таны амнаас гарсан бүхнийг тэр байтугай

таны бодлыг хүртэл мэддэг. Бурханы хаант улс нь үг хэллэгээр биш харин хүч чадалд байдаг.

Тиймээс Ариун Сүнсний хүч илэрхийлэгддэг. Энэ хүч танд хэзээ хэрэгтэй вэ?

Давидыг дайнд явж байхад энэ хүч хэрэгтэй байсан бөгөөд Бурхан бол миний хүч чадал гэж дуудсан.

Таны бүх асуудлуудыг шийдэх, хэцүү цагт танд хэрэгтэй байдаг тэрхүү хүч хаанаас ирдгийг ойлгож мэдээрэй. Хүний хүч тийм ч их өөр биш, харин Бурхан бол бүхнийг чадагч; тэр бүх зүйлийг Өөрийн хүчээр тогтоодог.

Та шүүгдэхдээ "Таван хэмжигдэхүүнээр" хэмжигдэх болно. Энэ шүүлт мөнхөд үлдэх болно.

- 1) Судрын үгийн дагуу
- 2) Та өөрийн хэмжээсний стандартын дагуу
- 3) Та хэлсэн үг ярианыхаа дагуу
- 4) Бусдад хандах хандлагынхаа дагуу
- 5) Их Эзэнд хийсэн зүйлийнхээ дагуу

#### **141.6 ТУСГААРЛАЛТЫН ТЭМДЭГ**

Дэлхийгээс тусгаарлагд; Бурханы хайж байгаа тийм хүн нь байх; нэг амьдрал, нэг чиглэл, нэг Эзэн, нэг найдвар, нэг бие, нэг сүм, нэг Сүнс, нэг баптисм, нэг итгэл, нэг тушаал; Христ доторх тэр гайхалтай амьдралаар амьдрах (ӨШД Тэмдэглэл 75.1ийг хар)

#### **141.7 ЗАГАЛМАЙГАА ҮҮРЭЭД, ДАГА**

Загалмайгаа үүрээд намайг дага гэдэг нь сэтгэл хөдлөлдөө татагдахгүй гэсэн үг юм. Сэтгэлийн хөдөлгөөн нь биднийг зөвт

байдлын шулуун замыг ба мөнхийн амьдралыг үл харахад хүргэдэг ба харин биднийг буруу зам өөрийн зам руу чиглүүлдэг.

Бурханы хайр нь эцэг эх эсвэл хүүхдүүдийг хайраас дээгүүр байх ёстой. Ингэснээр та тэднийг удирдахдаа жинхэнэ хайраар хучих юм. Хайр нь биднийг Үгтэй ойр байж, Үгээр амьдарч бусдыг шархлуулахгүй байхад чиглүүлдэг. Та ямар ч зүйлийг Бурханы Үгэн дээр суурилан үйлдэнэ. Тиймээс өөрийн туршлага эсвэл хүмүүсийн арга зам дээр биш харин Бурханы Үгэн дээр үндэслэн үйлд. Үгэн дээр нь баригдаагүй бүх зүйлс цаг нь болохоор шатаагдах болно гэж Бурханы Үгэнд хэлсэн байдаг.

#### **141.8 ДЭЛХИЙН АМЬДРАЛ ДАХЬ ШАГНАЛ**

Сүнсэн дотроо ядуу хүмүүс ерөөлтэй ээ. Учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм. Тиймээс дэлхий дээр өнөөдөр тэнгэрийн хаанчлал байг. Христ дотор таньд өгөгдсөн зөвт байдлаас бат зуурч таньд өгөгдсөн Үгийг дага.

Баяр хөөртэйгээр дуулгавартай байж, бузар мууг үзэн ядаж Түүний оршихуйд төгс бай. Өөрийнхөө шудрага байдлыг хадгалж өөрийн амьдралаа амьд ариун тахил болгож Эзэнд итгэж хийх байгаа зүйлдээ зоригтой, хүчтэй бай. Тэгвэл Тэрээр таныг шулуун замаар хөтөлж, энэ амьдралд хүчтэй болгож бэрхшээлтэй үед хариулж, хоргодох газар болж, зөв шудрагын дагуу шагнаж, толгой болгож хийсэн бүхнийг нь ерөөж хадан суурин дээр өндийлгөж үр жимсээр нь дамжуулж Өөрийн нэрээ алдаршуулна. Талантын тухай сургаалт зүйрлэлийг бодоод Бурханы алдаршуулах боломжоо бүү алдаарай.

#### **141.9 МЯНГАНЫ ШАГНАЛ**

Мянга жилийн хаанчлал нь тэрхүү үр жимс бөгөөд, тахилчдын төлөө бэлтгэгдсэн шагнал юм. Энэ нь гайхалтай цаг үе юм. Энэ талаар зааж сурга. Тэрхүү шагнал нь олон сүм барилга барих эсвэл их өргөл өгснийг нь тооцсоноор биш харин дуулгавартай байдлын үйлс юм. Биеэ бузарлаж шуналаар дүүрч, шуналын үдсэн дээр эд хөрөнгө цуглуулах нь шүүгдэнэ. Бичигдсэнчлэн Есүсийн дахин ирэлтээр шүүгдэнэ гэдгийг сана. Бүү мэхлэгд харин тэнгэрийн хаанчлалын төлөө бэлэн бай. Бурханы үгэнд биш хүний үгэнд итгэх нь дайсанд мэхлэгдсэн гэсэн үг юм. Тэнгэрлэг ажлыг өөрийн бодол эсвэл хэн нэгний үгээр хийдэггүй. Шүүлт нь Бурханы жишигээр Үгэнд бичигдсэнчлэн байх болно.

Ажлыг юуны тулд хийж байгаа вэ? Төлөвлөсөн зүйлээ мөнгөөрөө хийх нь итгэлийн үйлс биш юм. Энэ нь дэлхийн ажил юм. Энэ амжилт нь Бурханыг биш таныг алдаршуулна. Тиймээс өөрт аль хэдийн байгаа зүйл дээр биш харин Түүний чиглүүлэг болон Ариун Сүнсээр дайжих Түүний Үгэн доторх амлалтын дагуу тулгуурлан төлөвлө.

Түүний ажлыг гүйцэлдүүлэхэд хэрэгтэй хүч ба нөөцийг Яхова Бурхан таньд өгөх болно. Түүний ажлыг хийх итгэлтэй үйлчлэгч бол. Эдгээр нь Түүний Хаанчлалыг бүтээгчид юм. Итгэл бол Бурханы Үгэнд сайн дураараа захирагдах байдал юм.

#### **141.10 БУРХАН Л ТАНЫ ШАГНАЛЫГ МЭДНЭ**

16 Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж, жимс ургуулж, та нарын үр жимс үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг томилсон. Ингэснээр Миний нэрээр та нар Эцэгээс юуг ч гуйсан Тэр та нарт өгөх юм. (Иохан 15:16 АБ2004)

Үүнийн учир л Бурхан таныг сонгосон юм. Агуу хүчит Бурхан таныг ерөөхийг хүсдэг.

Бурханаас өөр хэн ч бидний тэнгэр дэхь шагнал юу байхыг мэдэхгүй. Нигүүлсэл, өршөөлийн Бурхан үр жимсээр нь тань гэсэн. Түүний хүслийн дагуух үр жимс байгаа эсэхийг өөрөөсөө шалга. Дэлхий таныг яаж шүүдэгт бүү санаа зов. Дэлхийгээс нэр хүндлэлийг бүү хай. Харин эцэст нь таны үр жимс болон шагнал юу байх талаар санаа тавь.

Ерөөл гэдэг нь та Бурханы хангамж ба хамгаалалтын дотор байна гэсэн үг юм. Та Бурханы ерөөлийг тэнгэрээс дэлхий уруу авчрах суваг болдог. Залбирлын аяга хальж, Бурхан таны тахилыг хүлээн авахад Бурханаас ирэх ерөөлийн үүд нээгддэг. Түүний амлалтын Үг ба бидний залбирлын бялхсан аяга бол үйлс гаргах цаг болсныг илтгэнэ.